

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 04

Дархан –Уул аймаг

Тогтоолын шийдвэрийг баталгаажуулах  
тухай

Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оын 03-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн дөрөв, тав дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 14-ны өдрийн 25/05 тоот тогтоолын 2024 оны “Ногдол ашиг хуваарилах тухай” шийдвэрийг дэмжиж баталсугай.
2. Мөн Дархан нэхий ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 сарын 26-ны өдрийн 24/46 тоот тогтоолын толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмших “Компанийн хувьцаа нэмж авах тухай” шийдвэрийг дэмжиж баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

дугаар 24/46

Дархан-Уул аймаг

## Компанийн хувьцаа нэмж авах тухай

Төсвийн нэгдсэн бодлогын журам батлагдсантай холбоотой “Нэхий хуримтлал” санг үүсгэж Дархан нэхий ХК-ийн ажилтнууд өөрсдийн хийж бүтээсэн баялагаас шударгаар хувь хүртэх, харилцан ашигтай байх, ажилтны нийгмийн баталгааг хангах, боловсон хүчний урт хугацаат хөтөлбөрт хамруулах зорилгоор одоогийн охин компаниудын эзэмшиж буй хувийг нэмэгдүүлэх, ашгийн жигд хуваарилалтыг хангах зорилгоор зарим нэг хувьцаа эзэмшдэггүй охин компаниуд дээр нэмж хувьцаа авах шаардлагатай байгааг харгалзан **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн охин компаниудын нийт эзэмшил хувийг 18,128% -иас 30% болгож нэмэгдүүлэн нэмж Дархан нэхий ХК-ийн 11,872% хувьцааг авахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцааны эзэмшилгүй байгаа Гранд як ХХ компани –д 5%, Нэхий трейд ХХК-д 2,0% -ийн хувьцаа худалдан авах хувьцааны эзэмшлийн хязгаарыг тогтоож уг хувьцааг худалдан авахтай холбоотой зардлыг компанийхаа ашгиасаа гарган НТТ ХХК-иар дамжуулан худалдан авахыг Гранд як ХХК-ийн гүйцэтгэх захирал н.Мягмар Өлзий, Нэхий Трейд ХХК-ийн захирал н.Оюунтуяа нарт даалгасугай.
3. Нэмж худалдан авах хувьцаанаас үлдэж буй 4,372%-ийн хувьцааг компаниудын ажилтны тоо, ирээдүйн өсөлтийг харгалзан тогтоож хуваарилалт хийж, худалдан авалтыг зохион байгуулахыг Дархан нэхий ХК-ийн ерөнхий захирал н.Гэрэлмаад зөвшөөрсүгэй.
4. Хувьцааны худалдан авах хэлцлийн үнэ, хувьцаа худалдан авах энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж 2025 оны санхүүгийн жилд багтаан гүйцэтгэлийг ТУЗ-д тайлагнахыг ТУЗ-ийн дарга Э.Батсайханд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э. БАТСАЙХАН